

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР**



65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.04.17 № 156  
танай —ны № —т

ИХТАМИР СУМЫН ИТХ-ЫН  
НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Г Хандивын тайлангийн дүгнэлт

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцох Архангай аймгийн Ихтамир сумын “Монгол Ардын нам”-ын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2023 оны нөхөн сонгуульд оролцох Ихтамир сумын Монгол Ардын намын хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн Сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ихтамир сумын Монгол Ардын намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын


тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн, дүгнэлтийг үндсэн дээр хянан баталгаажуулж дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Ихтамир сумын Ихтамир сумын Монгол Ардын намын хороо нь 2023 оны нөхөн сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайллагнаагүй байна.

Ихтамир сумын Монгол Ардын намаас ирүүлсэн хандивын талаарх албан бичгийг хавсаргав.

Хавсралт: ... хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БАЙГАЛМАА